



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Дулаан хангамжийн шугам сүлжээ, дулаан дамжуулах төв /Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх тосгон/” барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 5,561,850,400.00 (таван тэрбум таван зуун жаран нэгэн сая найман зуун тавин мянга дөрвөн зуу) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Хэнтий Ус” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Хэнтий” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Батгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001795

17-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дугаар сарын ...-н өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"ХЭНТИЙ УС" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Бүртгэх дүн (төгрөг)
1	Дулааны шугам	2024	ф300-89м /хос/, ф200-308 м /хос// Цэвэр усны шугам ф150-2219 м	1	1,625,853,427.00
2	Дулаан дамжуулах төв №1	2024	Халаалт 4000 кВт ХХУ-2000 кВт	1	499,482,459.00
3	Дулаан дамжуулах төв №2	2024	Халаалт 4000 кВт ХХУ-2000 кВт	1	508,513,441.00
4	Дулаан дамжуулах төв №1-ийн шугам сүлжээ	2024	Дулааны шугам п4-п3, ф40-ф165мм-369мм	1	1,232,454,112.00
5	Дулаан дамжуулах төв №1-ийн шугам сүлжээ	2024	ф25-ф165мм	1	1,695,546,961.00
Нийт дүн					5,561,850,400.00
					(таван тэрбум таван зуун жаран нэгэн сая найман зуун тавин мянга дөрвөн зуу)